



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 41

Мандалговь

Автокраныг худалдах тухай.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.1“в” 3.2.6-гийн “а” заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын Хот тохижилт үйлчилгээний албанд ашиглагдаж байгаа Nissin Vannet маркийн 4286 ДУА улсын дугаартай автокраныг байгууллагын санал Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт зэрэг баримт бичгийг үндэслэн ажлын шаардлага хангахгүй болсон тул худалдахыг зөвшөөрсүгэй.

2. 1997 онд ашиглалтад орсон 4286 ДУА улсын дугаартай Nissin Vannet маркийн автомашиныг 3,0 сая төгрөгөөр худалдах доод үнийг тогтоон дуудлагаар худалдсугай.

3. Автомашиныг хүлээн авч дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Орон нутгийн өмчийн албанд даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ

